



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/111/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargal.ts@audit.gov.mn
Аудитор: Л.Нямтөмөр
Утас: 260512 Цахим хаяг:
Гэрээгээр гүйцэтгэсэн Сүлд-Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Гүндбаяр
Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	17
8.3 Албан шаардлага	17
8.4 Зөвлөмж	18
9 Аудитаар Илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
НАБТГ	Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХАГ	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/604

танай _____-ны № _____-г

ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ГАНБААТАР ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 126,040.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 216,930.0 сая төгрөгөөр, алдагдлыг 90,890.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 64,890.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 214,880.1 сая төгрөгийн зардал гарган, 149,989.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,173,586,416.80	1,162,163,569.30
1.1.2	Дансны авлага	3,764,535,019.93	789,573,447.02
1.1.3	Татвар, НДШ –ийн авлага		-
1.1.4	Бусад авлага	2,534,975,290.83	13,807,211,228.48
1.1.5	Түүхий эд материал		
1.1.6	Бараа материал	57,607,563,441.13	70,165,083,960.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,293,334,918.32	6,691,841,456.32
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	68,373,995,087.01	92,615,873,661.21
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	139,040,717,590.59	163,491,159,059.45
1.2.2	Биет бус хөрөнгө	339,788,473.27	417,006,007.77
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9	Дуусаагүй барилга		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	139,380,506,063.86	163,908,165,067.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	207,754,501,150.87	256,524,038,728.43
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,998,125,040.30	38,666,614,057.42
2.1.1.2	Цалингийн өглөг	1,007,187,284.00	3,027,741.00
2.1.1.3	Татварын өр	3,436,861,717.14	3,836,661,406.84
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7,922,581,265.61	12,374,728,185.93
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	322,965,513.74	5,925,230,530.68
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	16,669,943,461.15	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	39,357,664,281.94	60,806,261,921.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	269,093,360,000.00	449,926,064,941.84
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		

2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	269,093,360,000.00	449,926,064,941.84
2.2	Өр төлбөрийн нийт дүн	308,451,024,281.94	510,732,326,863.71
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(100,697,523,131.07)	(254,209,288,135.28)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(100,696,523,131.07)	(254,208,288,135.28)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	207,754,501,150.87	256,524,038,728.43

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	57,593,402,969.01	34,081,998,187.49
2	Борлуулалтын өртөг	96,785,309,392.47	135,283,667,320.94
3	Нийт ашиг(алдагдал)	(39,191,906,423.46)	(101,201,669,133.45)
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	22,449,124.56	881.82
6	Санхүүжилт, дэмжлэг /БОАЖЯ/	25,524,900,000.00	22,262,860,569.32
7	Борлуулагчийн урамшуулал болон тээвэр шатахуун /НАБТГ/	6,143,408,896.42	8,199,759,349.83
8	Бусад орлого	754,316,076.93	326,884,095.31
9	Борлуулалт, маркетингийн зардал	13,503,531,848.94	12,733,778,142.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	49,742,857,252.73	56,674,103,775.13
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	12,172,736,198.79	10,145,598,184.57
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(6,166,048.68)	(42,950,291.29)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(384,431,072.30)	18,988,393.45
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(82,556,554,746.99)	(149,989,606,236.71)
19	Орлогын татварын зардал	2,244,912.40	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(82,558,799,659.39)	(149,989,606,236.71)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(82,558,799,659.39)	(149,989,606,236.71)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,000,000.00		(17,830,057,077.21)	(17,829,057,077.21)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(308,666,394.47)	(308,666,394.47)
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00		(18,138,723,471.68)	(18,137,723,471.68)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(82,558,799,659.39)	(82,558,799,659.39)
2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,000,000.00		(100,697,523,131.07)	(100,696,523,131.07)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(3,522,158,767.51)	(3,522,158,767.51)
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00		(104,247,822,116.45)	(104,218,681,898.57)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(149,989,606,236.71)	(149,989,606,236.71)
2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,000,000.00		(254,209,288,135.28)	(254,208,288,135.28)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	89,711,086,530.59	71,646,459,699.19
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	57,523,994,412.85	33,837,346,758.32
	Төмөр замын гэрээт ажлын орлого	839,063,737.00	416,862,690.60
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Борлуулагчийн урамшуулал /НАБТГ/	5,763,396,718.03	9,109,286,650.61
	Татаас, санхүүжилтийн орлого	25,524,900,000.00	28,084,200,000.00
	Бусад мөнгөн орлого	59,731,662.71	198,763,599.66
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	164,641,124,456.75	220,357,671,250.85
	Ажиллагчдад төлсөн	41,949,017,944.76	51,455,998,608.10
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,510,170,100.00	10,638,133,448.53
	Бараа материал худалдан авахад төлсөн	89,541,983,940.10	118,138,758,046.65
	Ашиглалтын зардалд төлсөн	3,004,808,721.11	5,789,430,267.37
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,204,310,064.76	5,189,675,055.64
	Хүүний төлбөрт төлсөн		-
	Татварын байгууллагад төлсөн	1,135,026,830.00	3,870,235,567.40
	Даатгалын төлбөрт төлсөн	166,580,272.51	-
	Бусад мөнгөн зарлага	16,129,226,583.51	25,275,440,257.16
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(74,930,037,926.16)	(148,711,211,551.66)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,449,124.56	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		

	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	22,449,124.56	
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	68,180,659,875.02	33,127,443,725.84
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,858,872,922.98	2,177,054,416.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	55,981,100.00	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	56,265,805,852.04	30,950,389,309.84
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(68,158,210,750.46)	(33,127,443,725.84)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	138,725,000,000.00	180,827,232,430.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	138,725,000,000.00	180,827,232,430.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	138,725,000,000.00	180,827,232,430.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,363,248,676.62)	(1,011,422,847.50)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,536,835,093.42	2,173,586,416.80
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,173,586,416.80	1,162,163,569.30

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого	мян.төг	57,593,403.0	126,040,000.0	34,081,998.2	(91,958,001.8)	27.0
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	96,785,309.4	148,870,000.0	135,283,667.3	(13,583,332.7)	90.9
3	Нийт ашиг	мян.төг	(39,191,906.4)	(22,830.0)	(101,201,669.1)	101,178,839.1	4,432.8
4	БОАЖЯ санхүүжилт	мян.төг	25,524,900.0		22,262,860.6	22,262,860.6	100.0
5	Борлуулагчийн урамшуулал	мян.төг	6,143,408.9		8,199,759.3	8,199,759.3	100.0

6	Бусад орлого	мян.төг	776,765.2		345,872.5	345,872.5	100.0
7	Ерөнхий удирдлагын зардал	мян.төг	49,742,857.3	48,660,963.4	56,674,103.8	8,013,140.4	116.5
8	Борлуулалт маркетингийн зардал	мян.төг	13,503,531.8	19,349,036.6	12,733,778.1	(6,615,258.5)	65.8
9	Бусад зардал	мян.төг	12,563,333.3	50,000.0	10,188,548.5	10,138,548.5	203.8
9	Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян.төг	(82,556,554.7)	(90,890,000.0)	(149,989,606.2)	59,099,606.2	165.0
	Татварын дараах ашиг (алдагдал)		(82,558,799.6)	(90,890,000.0)	(149,989,606.2)	59,099,606.2	165.0
10	Хөрөнгө оруулалтын зардал	мян.төг	79,581,063.9	99,015,139.4	50,879,973.5	48,135,165.9	51.3
11	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	тонн	530,276	696,589	601,170	95,419	86.3
12	Борлуулсан бүтээгдэхүүн	тонн	451,839	680,361	557,596	122,765	81.9
13	Ажилтнуудын тоо /үндсэн болон гэрээт/	хүн	3,146	3,189	2,860	329	90.0
	Борлуулалт хангамжийн бааз	ширхэг	30	30	30	-	100.0
14	Баруун бүсийн үйлдвэр	шугам	13	12	12	-	100.0
15	Зүүн бүсийн үйлдвэр	шугам	8	8	8	-	100.0
16	Борлуулалтын цэгийн тоо	ширхэг	800	1,000	625	375	62.5
17	Агаарын бохирдлыг бууруулсан дүн	хувь	50-60		50		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага өглөгийн тооцоо нийлэлт, бараа материалын ашиглалт, программ хангамж, үйлдвэрийн ашиг, алдагдлын тооцоо, бараа материалын зардал, төлөвлөлт, ерөнхий нягтлан бодогчийн ажил хүлээлцэхтэй холбоотой асуудал, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт тооцоололтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 03-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Б.Долгорсүрэн, Д.Мөнхтуяа туслах аудитор Ц.Уртнасан, Б.Баттогтох нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/174 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бичилтүүд бүрэн тусгагдаагүй байна. Тухайлбал: Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/-ийг үндсэн хөрөнгийн нэр төрөл зүйлээр тус бүрд нь тодорхойлж өгөөгүй, шахмал түлшний үйлдвэрлэлийн өртгийн нэмэгдэл зардалд тусгах зардлын төрөл, хувь хэмжээг тодорхой тусгаагүй, хадгалалтын хэвийн хорогдол, мидлингийг тээврийн жолоочоос хүлээн авах үеийн хорогдол, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртгийг бэлтгэх арга зэрэг асуудлыг тодорхой зааж өгөөгүй байна. Дээрх асуудлаар өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийн дагуу НБББББ-д нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байна.

Тус байгууллагын Дотоод хяналт-хууль эрх зүйн алба нь 2021 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлийн улмаас учирсан бодит хохирлыг барагдуулах, зөрчил гаргасан ажилтнуудад зохих хариуцлага тооцуулж, холбогдох алба хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлэн ажиллаж ирсэн байна. Тухайлбал, нэг талаас санхүүгийн баримтын бүрдэл болон худалдан авалтын гүйцэтгэлийг үнэн зөв нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэхийг, нөгөө талаас худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу үнэн зөв явагдаж байгаа эсэхэд ажлын хэсгийн гишүүд холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэл, хяналтын төсөв, ажлын даалгавар, ажлын

зураг болон тушаал, шийдвэрийн байдалд түүвэрчлэн шалгаж зөвлөмж өгч ажиллажээ. Мөн НБББББ-т оруулах өөрчлөлтийн саналыг санхүүгийн албатай хамтран боловсруулж саналаа нэгтгэн гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн байна. Үйл ажиллагааны хувьд Монгол улсын Хөдөлмөрийн хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, ажилтны ёс зүйн дүрмийг тус тус баримтлан дотоод хяналт шалгалтын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан болон удирдлагын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, шалгалтын дүнг тухай бүрд нь танилцуулан ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 172,595.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 862.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж нийт зардал өмнөх оноос 24.5 хувиар өссөн тул материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 214,880.1 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 1,074.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Таван толгой түлш ХХК-ийн зорилгыг “Чанарыг эрхэмлэн, хямд үнэ өртөг бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмрээ оруулах болон Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангаж агаарын бохирдлыг бууруулахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг шахмал түлшний үйлдвэрлэл, гадаад дотоод худалдаа эрхэлж болно” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчийн статустай байна. Өмчийн 49.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 39.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 10.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Таван толгой түлш ХХК нь ЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар тэмдэглэлийн “Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай” хуралдааны шийдвэрийг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “ЗГ нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.7 ” ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;...” гэсэн заалттай нийцэж байна.

Таван толгой түлш ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, ЗГ-ын газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын ЗГ-ын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Компанийн засаглалыг сайжруулах зорилтын хүрээнд ЗГ-ын 316 дугаар тогтоолын дагуу компанийн эзэмшлийн хувийн асуудлыг тодорхой болгож түүнтэй холбогдуулан компанийн дүрмийг шинэчлэн баталж, ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга нарыг томилсон байна.

ЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж , чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулан батлаагүй ч, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨХБАУ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- ЗГ-ын 2021 оны 207 дугаар тогтоолын 1 дэх заалт “Сайжруулсан шахмал түлшний үнийг 50 хувиар хөнгөлөх” тухай

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Таван толгой түлш ХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан СТОУС -ын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,173,586.4	1,162,163.6	(1,011,422.8)
Авлага	6,299,510.3	14,596,784.7	8,297,274.4
Урьдчилгаа	2,293,334.9	6,691,841.4	4,398,506.5
Бараа материал	57,607,563.4	70,165,084.0	12,557,520.6
Үндсэн хөрөнгө	139,040,717.6	163,491,159.0	24,450,441.4
Биет бус хөрөнгө	339,788.5	417,006.0	77,217.5
Нийт хөрөнгийн дүн	207,754,501.1	256,524,038.7	48,769,537.6
Өр төлбөрийн дүн	308,451,024.2	510,732,326.8	202,281,302.6
Богино хугацаат өглөг	39,034,698.7	54,881,031.3	15,846,332.6
Урьдчилж орсон орлого	322,965.5	5,925,230.5	5,602,265.0
Урт хугацаат өглөг	269,093,360.0	449,926,064.9	180,832,704.9
Эздийн өмч	(100,696,523.1)	(254,208,288.1)	(153,511,765.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	207,754,501.1	256,524,038.7	48,769,537.6

Касс дахь бэлэн мөнгө 35.1 сая төгрөг, арилжааны банканд дахь харилцах дансанд 1,127.1 сая төгрөг байршиж байна. Харилцах дансны үлдэгдлээс 3.9 сая төгрөг төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршиж байна.

Тайлант онд авлага 14,596.8 сая төгрөг болж 8,297.3 сая төгрөгөөр өссөн нь түүхий эдийн худалдан авалттай холбоотойгоор байгууллагуудаас авах авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 14,459.0 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 137.8 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Хугацаа хэтэрсэн 137.8 сая төгрөгийн авлага нь 2019-2020 онд үүссэн гэрээт борлуулагч нараас авах шахмал түлшний борлуулалтын авлага бөгөөд дээрх авлагаас 13.8 сая төгрөг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд байна. Авлагын үлдэгдэлд борлуулалтын авлага 789.6 төгрөг, бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой авлага 13,807.2 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 70,165.1 сая төгрөг болж 12,557.5 сая төгрөгөөр өссөн нь сайжруулсан шахмал түлшний түүхийн эдийн нөөцлөлтөөс шалтгаалжээ. Тайлант онд бараа материалын данс 4,761.3 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн, ашиглалтын хугацаа дууссан 33,885 нэр төрлийн 3,497.9 сая төгрөгийн бараа материалыг ТУЗ-ийн шийдвэрээр акталж устган ТУЗ-ийн 2021 оны 40 дүгээр тогтоолын дагуу данснаас хассан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 1,941 нэр төрлийн 1,650.7 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь бараа материалын тооллогоор ашиглах боломжгүй бараа материалуудыг цаг тухай бүрд нь удирдлагад танилцуулж акталж устгуулж байгаагүйтэй холбоотой юм.

Үндсэн хөрөнгийн өөрийн болон санхүүжилтийн хөрөнгөөр олж бэлтгэсэн 2,177.0 сая, бараа материалын данснаас шилжүүлэн авсан 4,761.3 сая, хөрөнгө оруулалтаар бий болсон 28,051.3 сая, хөрөнгө капиталжуулсан 2,153.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн данс тайлант онд байгуулсан 12,693.1 сая төгрөгийн элэгдлээр буурсан байна.

Биет бус хөрөнгө худалдаж авсан 77.0 сая төгрөгийн программ хангамжийн дүнгээр нэмэгджээ.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 54,180.5 сая төгрөг болж өмнөх оноос 9,738.8 сая төгрөгөөр өссөн байна. Дуусаагүй барилга данс 54,180.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тухайн ажлын гүйцэтгэл дуусаагүйтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчид төлөх өглөг 47,637.6 сая төгрөг, татвар нийгмийн даатгалын байгууллагад төлөх өглөг 16.2 сая төгрөг, гэрээт тээврийн жолооч нарт төлөх өглөг 7,224.2 сая төгрөг, цалингийн өглөг 3.0 сая төгрөг байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 5,925.2 сая төгрөг болж 5,602.3 сая төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-аас олгосон санхүүжилтийн зарцуулалт хийгдээгүйтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 449,926.1 сая төгрөг болж 180,832.7 сая төгрөгөөр өссөн нь Эрдэнэс таван толгой ХК-ийн тайлант хугацаанд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Шалгагдагч байгууллагын НБББББ-т орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг орлого, зардал зохицох зарчмын дагуу гарсан зардал болон өртгийг түүнтэй холбоотой орлогод шууд хамааруулах үндсэн дээр тусгахаар заасан байна

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт маркетингийн зардал, ерөнхий удирдлагын зардал болон бусад зардал гэж ангилсан байна.

Хуримтлагдсан алдагдлын данс 254,209.3 сая төгрөг болж 153,511.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны алдагдал 149,989.6 сая төгрөг, өмнөх үеийн үр дүн рүү залруулсан 3,522.1 сая төгрөгийн залруулгаас шалтгаалжээ.

Өмнөх 2019-2020 онд хуучирч муудан цаашид ашиглах боломжгүй болсон материалуудыг тайлант онд ТУЗ-ийн 40 дүгээр тогтоолын дагуу акталснаас шалтгаалан өмнөх алдагдлыг 3,497.9 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Мөн бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгүүдийг өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэж түүнтэй холбоотойгоор элэгдлийн зардлыг нөхөн байгуулснаар алдагдлыг 24.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Таван толгой түлш ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 126,040.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 216,930.0 сая төгрөгөөр, 90,890.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 99,015.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 64,890.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 214,880.1 сая төгрөгийн зардал гарган, 149,989.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 64,890.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 61,199.5 сая төгрөг буюу 51.5 хувиар тасарсан нь ЗГ-ын 2021 оны 207 дугаар тогтоолын дагуу сайжруулсан шахмал түлшний үнийг 50.0 хувиар хөнгөлсөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 214,880.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,050.0 сая төгрөг буюу 0.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь зарим зардал төлөвлөснөөс бага гарснаас шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 26 нэр төрлийн 3 ажилд Эрдэнэс таван толгой ХК-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй өөрийн эх үүсвэрээс 50,880.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 149,989.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 59,099.6 сая төгрөгөөр илүү байгаа нь сайжруулсан шахмал түлшний үнийг төрөөс хатуу тогтоож өгсөн нь нөлөөлж байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Таван толгой түлш ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т хамаарах байгууллага бөгөөд 3.1.3-т хамаарах байгууллагынхаа хувьд тайлант онд мэдээлэх ёстой нийт 96,089.7 сая төгрөгийн 81 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаандаа ил тод, бүрэн байршуулсан байна.

Тус байгууллага нь шилэн дансны хуулийн 3.1.3-т хамаарах байгууллага боловч шилэн дансны нэгдсэн системд 3.1.1, 3.1.2 -т хамаарах байгууллагуудын нэгэн адил мэдээлэх үүрэг үүсэж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.8. "Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яаманд хандан шилэн дансны нэгдсэн системд мэдээлэх шаардлага үүссэн мэдээллийг байршуулах цэсийг нь нээлгэх асуудлыг тавьж, шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд хөдөлгөөн хийгдээгүй, ашиглагдаагүй боловч ашиглах боломжтой 11.6 сая төгрөгийн идэмхий натри болон түүхий нүүрс бүртгэлд тусгагдсан байна. Мөн хуучирч муудаж цаашид ашиглах боломжгүй болсон 1,650.6 сая төгрөгийн материал бүртгэлд тусгагджээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 5.1.5. "хэмжигдэхүйц байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглагдахгүй байгаа материалыг хуучирч муудахаас сэргийлж эдийн засгийн үр өгөөж авчрах арга хэмжээ авах, хуучирч муудаж цаашид ашиглах боломжгүй болсон материалыг ТУЗ-өөр шийдвэрлүүлэх албан шаардлага өгөв.

2. Мөнгөн урсгалын төсвийн төлөвлөгөөнд 4 төрлийн зардлыг өмнөх оноос 447.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахгаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөх, тэвчиж болох зардлыг нэмж төсөвлөхгүй байх зөвлөмж өгөв

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай, өмнөх оноос зардлыг нэмэгдүүлж баталсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 13,489.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 5,379.2 сая төгрөгийг залруулж, 7,645.7 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 464.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 72.4 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 1,968.1 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгснөөс албан шаардлага 85.7 хувь, зөвлөмж 90.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	7	72,400.0	6	72,400.0	1	-	85.7
Зөвлөмж	11	1,968,100.0	10	1,444,700.0	1	523,400.0	90.9
Нийт дүн	18	2,040,500.0	16	1,517,100.0	2	523,400.0	88.3

/мянган төгрөг/

Борлуулагчийн урамшууллаас ХХОАТ суутган тооцохгүй олгосон зөрчил давтагдсан тул зөрчлийг арилгах албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул сахилгын шийтгэл тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус компанийн баруун үйлдвэрт гарсан гал түймрээс шалтгаалан учирсан хохирлын хэмжээ, шатсан тоног төхөөрөмж, материалын тоо хэмжээ үнэ өртөг, худалдан авах ажиллагаанд биет тест хэрэгжүүлэх, сайжруулсан шахмал түлшний өртгийн тооцооллыг шалгах нь зүйтэй гэж үзэв.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,231.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,392.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 22.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 397.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 419.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 838.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 1,074.4 сая төгрөгийн түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,392.8 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 112.4 сая төгрөгөөр илүү тооцсон;
- Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалд төлсөн мөнгийг 1,280.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;

8.2 Төлбөрийн акт

1. Ковид-19 цар тахалтайгаар холбоотойгоор Дундговь аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 10.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т *“үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”*, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д *“үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн хөрөнгийг төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах, төлбөрийн акт тогтоов.

2. Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу Хөл бөмбөгийн “Илч спорт клуб”-ыг 6.3 сая төгрөгөөр санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д *“үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах, төлбөрийн акт тогтоов.

3. Ажилчдын ажилласан цагийн бүртгэлийг буруу бодсоноос зарим ажилчдад 5.8 сая төгрөгийн цалинг илүү олгосон нь Таван толгой түлш ХХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын есдүгээр бүлгийн *“ажил, амралтын цагийн горим, захиргааны чөлөөний дагуу ажилтны ажилласан цагийг үнэн зөв бүртгэж тайлагнах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. *“үнэн зөв байх”* заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

1. ЗГ-ын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг үндэслэн ЗГХЭГ-аас гаргасан хүсэлтийн дагуу Энержи ресурс ХХК-иас үнэ төлбөргүй нийлүүлж байгаа угаасан нүүрс буюу мидлингийн өртгийг Өмнөговийос Улаанбаатар хүртэлх тээврийн хөлсөөр бүртгэж, үндсэн түүхий эдийн үнийг өртөгт тусгаагүй байгаа талаар өмнөх онд өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй борлуулагчид олгосон борлуулалтын урамшууллаас нийгмийн даатгал суутган тайлагнаж байгаа боловч 397.1 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутгалгүй олгосон нь МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалын 4.2.1.10. *“аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг*

хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Баруун, зүүн хоёр үйлдвэрийн ашиг алдагдлын тооцоо тусдаа гардаггүй, нягтлан бодох бүртгэлд үйлдвэр бүрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон борлуулан бүтээгдэхүүний тоо хэмжээ, өртгийн зардал зэргийг тусад нь бүртгэдэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.2."Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Баруун, зүүн хоёр үйлдвэрийн ашиг алдагдлын тооцоог тусад нь гаргаж, санхүү бүртгэлд орлого, өртөг зардлыг тусад нь бүртгэж тайлагнах;

2. Ажил хүлээлцэхтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон бөгөөд өмнөх ерөнхий нягтлан бодогчтой ажил хүлээлцээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл "12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Гүйцэтгэх захирлын тушаал гаргаж, ажлыг актаар хүлээлцүүлж хэвших;

3. Программ хангамжтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн программ хангамж нь өртгийн хуваарилалт гараас хийдэг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг буруу тооцоолдог, валютын гүйлгээний үлдэгдэл валютаар гардаггүй зэрэг сул талуудтай байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 03-р сарын 47 дугаар тоот тушаалын Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах ерөнхий шаардлагын 1.10 "санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэрийг иж бүрнээр / анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх", тусгай шаардлагын 2.2 "мэдээлэл үнэн зөв, иж бүрэн байх, 2.6 ашиглахад энгийн ойлгомжтой байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Программ хангамжийг өөрийн үйл ажиллагаа болон НБББББ-т нийцүүлэн сайжруулах;

4. Авлага, өглөгийн үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан 378.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "эр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

4.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан гарахаас өмнө харилцагчидтай тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулж байх;

5. Цалингийн зардалтай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу сахилгын шийтгэлтэй ажилтны үндсэн цалинг 1-3 сар хүртэлх хугацаатайгаар 20.0 хувиар бууруулах журамтай боловч сахилгын шийтгэлийг ажилтны үндсэн цалинг бууруулахгүйгээр, гарт олгох дүнгээс суутган тооцсоноос шалтгаалан зарим ажилчдад 1.8 сая төгрөгийн цалин дутуу олгож, байгууллагын төлөх НДШ-ийн зардал 0.7 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10-д зааснаар "Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Гүйцэтгэх захирлын эрхийн хүрээнд гаргасан тушаал шийдвэрийг дагаж мөрдөх, тушаалд хяналт тавьж ажиллах;

6. Татварын тайлагнал болон хөнгөлөлттэй холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Борлуулагч нарт олгох урамшууллаас нийгмийн даатгал суутган тайлагнаж байгаа боловч ХХОАТ суутган тайлагнахгүй байгаагаас шалтгаалан ХХОАТ-ын тайланд 28.7 сая төгрөгийн цалин хөлс дутуу тусгагдсан байна. Мөн 2021 оны жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг нэгтгэж тооцоолоогүйгээс зарим ажилчдад 5.3 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу, 3.9 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн "23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Борлуулагчид олгох урамшууллаас ХХОАТ суутган тайлагнах асуудлыг дээд удирдлагаар шийдвэрлүүлэх, ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн эцэст нэгтгэн тооцоолж, татварыг үнэн зөв тайлагнаж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9 Илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг илүү тооцон бүртгэлд тусгасан	Залруулсан	1	1,280,441.2	1	1,280,441.2								
2	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалд төлсөн мөнгийг дутуу тайлагнасан	Залруулсан	1	112,438.9	1	112,438.9								
3	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт буцалтгүй тусламж олгосон	Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, төлбөрийн акт тогтоов	1	10,000.0			1	10,000						
4	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Хөл бөмбөгийн "Илч спорт клуб"-ыг санхүүжүүлсэн	Төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, төлбөрийн акт тогтоов	1	6,313.0			1	6,313.0						
5	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Ажилчдын ажилласан цагийн бүртгэлийг буруу бодсоноос зарим ажилчдад цалинг илүү олгосон	Хяналтыг сайжруулах, төлбөрийн акт тогтоов	1	5,805.1			1	5,805.1						
6	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Энержи ресурс ХХК-иас үнэ төлбөргүй нийлүүлж байгаа угаасан нүүрс буюу мидлингийн өртгийг Өмнөговьос Улаанбаатар хүртэлх тээврийн хөлсөөр бүртгэж, үндсэн түүхий эдийн үнийг өртөгт тусгаагүй, өмнөх онд өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй.	Сахилгын шийтгэл тооцох албан шаардлага хүргүүлэв	1	-						1	-			

Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй борлуулагчид олгосон борлуулалтын урамшууллаас нийгмийн даатгал суутган тайлагнаж байгаа боловч ХХОАТ-ыг суутгалгүй олгосон	Борлуулагчид олгох урамшууллаас ХХОАТ суутган тайлагнах асуудлыг дээд удирдлагаар шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв	1	397,076.8												1	397,076.8
8	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Баруун, зүүн 2 үйлдвэрийн ашиг алдагдлын тооцоо тусдаа гардаггүй, нягтлан бодох бүртгэлд үйлдвэр бүрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон борлуулан бүтээгдэхүүний тоо хэмжээ, өртгийн зардал зэргийг тусад нь бүртгэдэггүй байна.	2 үйлдвэрийн ашиг алдагдлын тооцоог тусад нь гаргаж, санхүү бүртгэлд орлого, өртөг зардлыг тусад нь бүртгэж байх	1	0.0												1	0.0
9	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Тус байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь гүйцэтгэх захирлын 2021 оны 11 сарын 09-ний өдрийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон бөгөөд өмнөх ерөнхий нягтлан бодогчтой ажил хүлээлцээгүй байгаа	Гүйцэтгэх захирлын тушаал гаргаж, ажлыг актаар хүлээлцүүлж хэвших	1	0.0												1	0.0
10	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Санхүүгийн программ хангамж нь өртгийн хуваарилалт гараас хийдэг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг буруу тооцоолдог, валютын гүйлгээний үлдэгдэл валютаар гардаггүй зэрэг сул талуудтай байна	Программ хангамжийг өөрийн үйл ажиллагаа болон НБББББ-т нийцүүлэн сайжруулах	1	0.0												1	0.0
11	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байгаа нь	Санхүүгийн тайлан гарахаас өмнө харилцагчидтай үлдэгдлийг тооцоо нийлэн баталгаажуулж байх	1	378,594.5												1	378,594.5
12	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Сахилгын шийтгэлийг гарт олгох дүнгээс суутган тооцоноос шалтгаалан зарим ажилчдад цалин дутуу олгож, байгууллагын төлөх НДШ-ийн зардал илүү дүнгээр тайлагнагдсан байна	Гүйцэтгэх захиралын эрхийн хүрээнд гаргасан тушаал шийдвэрийг дагаж мөрдөх, тушаалд хяналт тавьж ажиллах	1	2,492.2												1	2,492.2

Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Борлуулагч нарт олгох урамшууллаас нийгмийн даатгал суутган тайлагнаж байгаа боловч ХХОАТ суутган тайлагнахгүй байгаагаас шалтгаалан ХХОАТ-ын тайланд 28.7 сая төгрөгийн 1цалин хөлс дутуу тусгагдсан байна. Мөн 2021 оны жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг нэгтгэж тооцоолоогүйгээс зарим ажилчдад 5.3 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу, 3.9 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.	Борлуулагчид олгох урамшууллаас ХХОАТ суутган тайлагнах асуудлыг дээд удирдлагаар шийдвэрлүүлэх, ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн эцэст нэгтгэн тооцоолж, татварыг үнэн зөв тайлагнаж байх	1	37,950.0									1	37,950.0
ДҮН					13	2,231,112.6	2	1,392,880.1	3	22,118.1	1	397,076.8	1	0.0	6	419,037.6
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Мөнгөн урсгалын төсвийн төлөвлөгөөнд 4 төрлийн зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж баталсан байгаа	Төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, тэвчиж болох зардлыг танах	1	447,700.0									1	447,700.0
2	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Тайлант онд хөдөлгөөн хийгдээгүй, ашиглагдаагүй боловч ашиглах боломжтой 11.6 сая төгрөгийн идэмхий натри болон түүхий нүүрс бүртгэлд тусгагдсан байна. Мөн хуучирч муудаж цаашид ашиглах боломжгүй болсон 1,650.7 сая төгрөгийн материал бүртгэлд тусгагджээ.	Ашиглагдахгүй байгаа материалыг хуучирч муудахаас сэргийлж эдийн засгийн үр өгөөж авчрах арга хэмжээ авах, хуучирч муудаж цаашид ашиглах боломжгүй болсон материалыг ТУЗ шийдвэрлүүлэх	1	1,662,175.5				1	1,662,175.5					
3	Таван толгой түлш ХХК	АХГ-2022/111/НА-СТА-ТӨА	Тус байгууллага нь шилэн дансны хуулийн 3.1.3-т хамаарах байгууллага боловч шилэн дансны нэгдсэн системд 3.1.1, 3.1.2 -т хамаарах байгууллагуудын нэгэн адил мэдээлэх эрх үүсч байна	Холбогдох дээд шатны байгууллагуудад хандан дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөв.	1	-									1	-
ДҮН					3	2,109,875.5				1	1,662,175.5			2	447,700.0	
НИЙТ ДҮН					16	4,340,988.1	2	1,392,880.1	3	22,118.1	2	2,059,252.3	1	0.0	8	866,737.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 522/АД150055

Улаанбаатар хот

АХГ-2022/91/НА-СТА-ТДА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Энержи ресурс ХХК-аас үнэ төлбөргүй нийлүүлж байгаа угаасан нүүрс буюу мидлингийн ертгийг Өмнөговийос Улаанбаатар хүртэлх тээврийн хөлсөөр бүртгэж, үндсэн түүхий эдийн үнийг ертөгт тусгаагүй байгаа талаар өмнөх онд өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Таван толгой түлш ХХК-ийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Р.Гансүхт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 15 № 592/А0150055

Улаанбаатар хот

АХГ- 2022 / 111/НА-СТА-Т0А

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:



Тайлант онд хөдөлгөөн хийгээгүй, ашиглаагүй боловч цаашид ашиглах боломжтой 11,600,000.00 төгрөгийн идэмхий натри болон түүхий нүүрс, цаашид ашиглах боломжгүй 1,941 нэр төрлийн 1,650,575,463.43 төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ашиглахгүй байгаа материалыг хуучирч муудахаас сэргийлж, эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээ авах, цаашид ашиглах боломжгүй болсон материалыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр шийдвэрлүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Таван толгой түлш ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ж.Батбаясгалан, гүйцэтгэх захирал М.Ганбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, 
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АХЛАХ АУДИТОР 

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ГҮНДБАЯР

4006109
9019120396

0001081404



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 15

№ 531/АО150055

Улаанбаатар хот

АХГ - 2022 / 111 / НА - СТН - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй борлуулагчид олгосон борлуулалтын урамшууллаас нийгмийн даатгал суутган тайлагнаж байгаа боловч 397,076,814.64 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгалгүй олгосон.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Борлуулагчийн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар суутган тооцож тайлагнах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч С.Бэлэгдэмбэрэл нарт даалгах.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ц.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 126/АД150055

Улаанбаатар хот

АХГ-2022/111/НА-СТА-ТРА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу Хөл бөмбөгийн "Илч спорт клуб"-ыг 6,313,000.00 төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр ашиггүй зарцуулсан 6,313,000.00 /зургаан сая гурван зуун арван гурван мянга/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч С.Бэлэгдэмбэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Газар-61.Docx

0001090294



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 125/А0150055

Улаанбаатар хот

АХТ-2022/111/НА-СТА-ТБА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковид-19 цар тахалтайгаар холбоотойгоор Дундговь аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 10,000,000.00 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр ашиггүй зарцуулсан 10,000,000.00 /арван сая/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 03 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч С.Бэлэгдэмбэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264730

110.10.10.20\Bichig_Khereg\Ак\2022\0315\Аудитин 4 Газар-62.Docx
0019120596

0001090296



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 124/А0150055

Улаанбаатар хот

АХГ-2022/11/НА-СТА-Т0А
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Таван толгой түлш ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдын ажилласан цагийн бүртгэлийг буруу тооцож, зарим ажилчдад 5,805,149.08 төгрөгийн цалинг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 үнэн зөв байх", Таван толгой түлш ХХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын есдүгээр бүлгийн "ажил, амралтын цагийн горим, захиргааны чөлөөний дагуу ажилтны ажилласан цагийг үнэн зөв бүртгэж тайлагнах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 5,805,149.08 төгрөгийн цалинг ажилтны цалингаас суутган авч, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Таван толгой түлш ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч С.Бэлэгдэмбэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

